



**ОРХОН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2026 оны 02 сарын 12 өдөр

Дугаар А/17

Баян-Өндөр сум

Бэлэн байдлыг хангах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.4 дэх хэсэг, Хөдөлмөрийн тухай хуулийн 97 дугаар зүйлийн 97.1.6, 109 дүгээр зүйлийн 109.4 дэх заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.3, 8.1.13 дахь заалт, Эрүүл мэндийн сайдын 2020 оны "Журам батлах тухай" А/36 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Сар шинийн баярын өдрүүдэд ажиллах хариуцлагатай жижүүр, хяналт тавиж ажиллах албан хаагчдын хуваарь, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед дуудагдан ажиллах албан хаагчдын нэрсийг нэгдүгээр хавсралтаар, Эрүүл мэндийн байгууллагуудын ажиллах хуваарийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Хариуцлагатай жижүүрийг баярын өдрүүдэд томилон ажиллуулж, эмнэлгийн яаралтай тусламж, эрчимт эмчилгээний тасгийн ор, хүний нөөц, багаж тоног төхөөрөмж, зайлшгүй шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслийн нөөц, вакцины хадгалалт, цахилгааны эх үүсвэр, автомашины бэлэн байдлыг ханган, харилцаа хандлага, ёс зүйн зөрчил гаргахгүй байх, сахилга дэг журмыг сахиулахад анхаарч, эмнэлгийн тусламж үйлчилгээг тасралтгүй шуурхай үзүүлэн хоол хүнсээр дамжих халдвар, Томуу, томуу төст, Улаанбурхан өвчний дэгдэлтийн үеийн хариу арга хэмжээ, эрсдлийн харилцаа холбоог идэвхжүүлэн ажиллахыг бүх шатны захирал, дарга нарт үүрэг болгосугай.

3. Хяналтад байгаа бага насны хүүхэд, өндөр настан, жирэмсэн эх болон эрсдэлт бүлэгт чиглэсэн гэрийн эргэлт хяналт, тусламж үйлчилгээг үзүүлж, мэдээ тайланг нэгтгэн ирүүлэхийг сум, өрхийн эрүүл мэндийн төвийн дарга нарт даалгасугай.

4. Иргэдэд зөвлөгөө өгөх, эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой санал, гомдлыг Эрүүл мэндийн газрын 70350659 нээлттэй утсаар хүлээн авч, шийдвэрлэж ажиллахыг хариуцлагатай жижүүрүүдэд даалгасугай.

5. "Журам шинэчлэн батлах тухай" Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2024 оны 73 дугаар зарлигаар батлагдсан загварын дагуу Эрүүл мэндийн байгууллагуудаас хоног тутмын мэдээг авч нэгтгэн Эрүүл мэндийн хөгжлийн төвд хугацаанд нь хүргүүлж, эргэн мэдээллээр хангаж ажиллахыг Эрүүл мэндийн газрын хариуцлагатай жижүүрүүдэд үүрэг болгосугай.

6. Улаанбурхан, томуу томуу төст өвчин, угаарын хийн болон хоол хүнсний хордлого, осол гэмтэл, осголт хөлдөлтөөс урьдчилан сэргийлэх, бага насны хүүхдийг хараа хяналтгүй орхихгүй байх чиглэлээр мэдээлэл сурталчилгааны ажлыг зохион байгуулж, бүртгэгдсэн нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн тохиолдлыг шуурхай мэдээлж, Тохиолдол удирдлагын тогтолцоонд шилжин хариу арга хэмжээг авч ажиллахыг Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн ахлах мэргэжилтэн (Н.Мөнгөнцацралт)-, Гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал, орчны асуудал хариуцсан мэргэжилтэн (Б.Оюуномин), Олон нийттэй харилцах ажилтан (Ц.Намуундарь) нарт даалгасугай.

7. Хариуцлагатай жижүүрээр ажилласан албан хаагчдад илүү цагийн хөлсийг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу бодож олгохыг Салбарын санхүү бүртгэл мэдээлэл, нягтлан бодохын ажилтан (Н.Чулуун-Эрдэнэ)--д болон байгууллагын дарга, захирал нарт зөвшөөрсүгэй.

8. Тушаалын хэрэгжилтийг хангаж, хяналт тавьж ажиллахыг Хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудит хариуцсан ахлах мэргэжилтэн (М.Бямбасүрэн)-д үүрэг болгосугай

ДАРГА



Ц.МӨНХЦЭЦЭГ

ЭМГ-ын даргын 2026-ны 02-сарын 12 өдрийн
 412-тоот тушаалын нэгдүгээр хавсралт



САР ШИНИЙН БАЯРЫН ӨДРҮҮДЭД АЖИЛЛАХ ХАРИУЦЛАГАТАЙ ЖИЖҮҮР, ХЯНАЛТ
 ТАВИЖ АЖИЛЛАХ АЛБАН ХААГЧДЫН НЭРС, ХУВААРЬ

Д/д	Албан хаагчийн овог нэр	Албан тушаал	Жижүүр хийх өдөр	Харилцах утасны дугаар	Хяналт тавих ажиллах ажилтны нэрс
1	Д.Отгондэлгэр	Эрүүл мэндийн эдийн засаг, төсвийн төлөвлөлт, зохицуулалт хариуцсан мэргэжилтэн	2026.02.17	99017763	ХШХ-ийн улсын ахлах байцаагч Д.Оюунтунгалаг 99353784
2	П.Хишгээ	Эмнэлгийн тусламжийн чанар, магадлан итгэмжлэл хариуцсан ахлах мэргэжилтэн	2026.02.18	99359900	
3	Н.Мөнгөнцацралт	Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний бодлого төлөвлөлт хариуцсан ахлах мэргэжилтэн	2026.02.19	94902471	ЭТҮХ-ийн ахлах мэргэжилтэн П.Хишгээ 99359900
4	М.Бямбасүрэн	Хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудит хариуцсан ахлах мэргэжилтэн	2026.02.20	88106661	Н.Мөнгөнц ацралт НЭМХ-ийн ахлах мэргэжилтэн 94902471
5	Д.Оюунтунгалаг	ХШХ-ийн улсын ахлах байцаагч Д.Оюунтунгалаг	2026.02.21	99353784	
6	А.Хонгорзул	Анхан шатны эрүүл мэндийн байгууллага, ахмад настны тусламж үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн	2026.02.22	95850851	ХШҮХ-ийн ахлах мэргэжилтэн М.Бямбасүрэн 88106661

НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН НОЦТОЙ БАЙДЛЫН ҮЕД ДУУДАГДАН АЖИЛЛАХ АЛБАН
 ХААГЧИЙН НЭРС

Д/д	Албан хаагчийн овог нэр	Албан тушаал	Утасны дугаар
1	П.Отгонбилэг	Дархлаажуулалт, зоонозын халдварт өвчний тандалт, сэргийлэлт хариуцсан мэргэжилтэн	99058187
2	Б.Оюуномин	Гамшиг, НЭМ-ийн ноцтой байдал, орчны асуудал хариуцсан мэргэжилтэн	99977913
3	С.Эрдэнэтунгалаг	Эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын байцаагч	99207048
4	Б.Солонго	Хүүхдийн эрүүл ахуйн улсын байцаагч	91113917
5	Б.Будсүрэн	Эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын байцаагч	99279278

ЭМГ-ын даргын 2026 оны 02 сарын 12 өдрийн
 А/Г тоот тушаалын хоёрдугаар хавсралт



САР ШИНИЙН БАЯРЫН ӨДРҮҮДЭЭР АЖИЛЛАХ ЭРҮҮЛ МЭНДИЙН
 БАЙГУУЛЛАГУУДЫН ХУВААРЬ

№	Байгууллагын нэр	Ажиллах хуваарь
Нэг. Эмнэлгийн анхан шатны тусламж үйлчилгээ		
1	Өрхийн эрүүл мэндийн төвүүд	2026 оны 2 сарын 17, 19, 20, 21, 22-ны өдрүүдэд 10:00-14:00 цаг хүртэл ажиллана.
2	Жаргалант сумын эрүүл мэндийн төв	Сар шинийн өдрүүдэд 24 цагаар ажиллана.
Хоёр. Эмнэлгийн лавлагаа шатлалын тусламж үйлчилгээ		
3	Бүсийн оношилгоо эмчилгээний төв Түргэн тусламж -7035103	Сар шинийн өдрүүдэд 24 цагаар ажиллана
4	Тайхар, Бадархундага ортой клиник /хэвтүүлэн эмчлэх/	2026 оны 2 сарын 20-ноос эхлэн 24 цагаар ажиллана.
Гурав. Эмийн сан		
5	Энэрэхзаяа /Зэст баг, 1-5 дугаар байр/ Орхон сөд /Зэст баг, 1-3 дугаар байр/	Сар шинийн өдрүүдэд 24 цагаар ажиллана
6	Монос Орхон БОЭТ /Зэст баг, Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн байр / Монос Орхонфарм маркет /Хүрэнбулаг баг, 4-14 байрны зүүн тал АНСА худалдааны төв/ Орхон-1, Орхон-2 /Бүрэнбүст баг цэнхэр аптек, Хүрэнбулаг баг, Уртцагааны баруун жигүүрт/ Элбэг фарм /Зэст баг 1-3 байр 14 тоот/ Сондор эмийн сан /Эрдэнэ баг 276 гудамж 15 тоот/	Сар шинийн өдрүүдэд 10:00-22:00 цаг хүртэл ажиллана
Дөрөв. Хүүхдийн тусламж үйлчилгээ		
7	Бүжинлхам хүүхдийн клиник 7-р хороолол Түмэн центр	2026 оны 02 сарын 21-нээс эхлэн өдөр бүр 09:00-18:00 цаг хүртэл ажиллана
8	Ве-һарру хүүхдийн клиник 6-15 дугаар байр	
Тав. Шүдний тусламж үйлчилгээ		
9	Хаш, Ганшунх, Централ дент, Лилидент, Нандин дент, Эрдэнэт дент	2026 оны 02 сарын 17-ны 09:00-13:00 цаг хүртэл ажиллана.
10	Нандин дент, Эмаль	2026 оны 02 сарын 20-ны 09:00-16:00 цаг хүртэл ажиллана.
11	Хаш, Шигтгэмэл, Шигшмэл эрдэнэ, Очир талст, Натурмед, Лилидент	2026 оны 02 сарын 21-нээс эхлэн өдөр бүр цагийн хуваарийн дагуу ажиллана.